



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2023.01.31 № А-1/198.

танай _____-ны № _____-т


Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн тайланг гарган хүргүүлж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Авлигатай тэмцэх газрын “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” цахим систем <http://khutulbur.iaac.mn> – д байршуулан баталгаажуулсан болно.

Хавсралт ¹⁹ ... хуудастай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

A-4/2022

139004183

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

(2022 оны жилийн эцэс)

Байгууллагын нэр: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Огноо: 2023.01.25

Д/д	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хоёр дахь үе шат (2020 - 2023) хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	ХҮРСЭН ТҮВШИН, ҮР ДҮН, Хэрэгжилтийн хувь
<p>Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх</p>						
1	<p>4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</p>	<p>1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох</p>	2017 - 2022	-	<p>1. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлтийн мэдээллийн санг хөгжүүлсэн байх</p> <p>2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн системийг хөгжүүлсэн байх</p>	<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Тайлант жилд тус байгууллагын 5 албан тушаалын сул орон тоонд Төрийн албаны зөвлөлд захиалга өгч, нөхөх арга хэмжээг авч ажилласан. Төрийн албаны зөвлөлд сул орон тооны захиалга өгч, сонгон шалгаруулалтын үр дүнд хамгийн өндөр оноо авсан 5 нэр дэвшигчийг Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсэн шийдвэр, дүгнэлтийн дагуу тухайн албан тушаалд томилж, Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн. 4 албан хаагчийг төрийн бусад байгууллагаас хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн ажиллуулсан байна. Тэдгээрийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсны үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу томилсон. ХАСУМ-ийг хянасан тухай дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд мэдээлж, нээлттэй байдлыг хангасан.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан тушаалд нэр дэвшигч этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем https://meduuleg.iaac.mn -ээр дамжуулан хүлээн авч бүртгэн, АТГ-т цахим хэлбэрээр</p>

					хүргүүлэн хянуулж хэвшлээ. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>
2		5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	2017 - 2022	Хүний нөөцийн системтэй уялдсан "Төрийн албаны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийн сан"-г хөгжүүлсэн байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) 2022 онд ТӨБЗГ-ын албан тушаалын жагсаалт, албан тушаалд шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн байдалтай холбоотой албан хаагчийн шилжилт, хөдөлгөөний судалгааг Хүний нөөцийн системтэй уялдуулан шинэчлэн гаргаж, байгууллагын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -ийн хүний нөөцийн ил тод байдал цэст байршуулан мэдээлэх арга хэмжээ авч байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, байгууллагын цахим хуудсыг хуульд нийцүүлэн шинэчлэх, хөгжүүлэх ажлыг хийв. Байгууллагын цахим хуудасны шинэчлэлийн хүрээнд зарим мэдээллийг шилжүүлэн байршуулах, шинэчлэх, өөрчлөх ажлуудыг хийсэн. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>
3	4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2022	1. Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байх 2. Шалгуурт нийцсэн ТЖАХ-ийн эзлэх хувь - 70%-аас дээш	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) Албан тушаалын тодорхойлолтод заасан ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн тус байгууллагын сул орон тооны 5 албан тушаалд томилогдох иргэдийг зохих журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэн ирүүлсэн шийдвэр, дүгнэлтийн дагуу томилох ажлыг зохион байгуулж байна. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд тавигдах тусгай шаардлага, шалгуурыг үндэслэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нэр

						дэвшүүлэх, томилох тогтолцоо бүрдсэн. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>
4	4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	2017 - 2022		Албан бичиг цахим орчинд баталгаажиж, мэдээлэл солилцох мэдээллийн систем бий болсон байх	ТӨБЗГ – МТА (Бүх шатны төрийн байгууллага) Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны http://docx.gov.mn системд холбогдсон. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 58 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэнтэй холбоотой албан бичиг солилцооны дундын системийг ашиглах зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>
5		2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах	2018 - 2022		Байгууллагуудын мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн байх	ТӨБЗГ – МТА (АТГ, холбогдох бусад байгууллага) Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 58 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэнтэй холбоотой албан бичиг солилцооны дундын системийг ашиглах зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны http://docx.gov.mn системийг байгууллагад хэрэглэж байгаа дотоод сүлжээний https://www.able.mn системтэй холбон ажиллуулж байна. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>
6	4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд:	2018 - 2022		Хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувь буюу 36387 албан хаагчийг давтан сургасан байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд сургалт, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн тусгаж, хэрэгжилтийг хангаж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг судлан Авлигатай тэмцэх газрын УССГХ-т сургалт авах

					<p>санал өгч, сургалтын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авсан.</p> <p>АТГ-тай хамтран зохион байгуулсан дараах сургалтуудад нийт 170 албан хаагчийг хамруулсан:</p> <ul style="list-style-type: none"> – Анхан шатны сургалт, 2022.02.23, цахимаар – 40 албан хаагч (ТӨХЭТгээд); – Давтан сургалт, 2022.02.24, цахимаар – 20 албан хаагч (ТӨБЗГ); – Давтан сургалт, 2022.03.04, цахимаар – 20 албан хаагч (ТӨХЭТгээд); – “Төрийн байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүй, манлайллыг дээшлүүлэх, авлигын шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, таслан зогсоох нь” авлигын эсрэг давтан сургалт, 2022.03.30, танхимаар – 30 (ТӨХЭТгээдийн удирдах ажилтан, УБ-д байршилтай.) – Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны сургалт, 2 удаа, цахимаар – 60 давхардсан тоогоор. <p>Мэдүүлэг гаргагч албан хаагчид болон харьяа байгууллагын ЭБАТ-ыг тухай бүр зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажилласан. Тайлант жилд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах чиглэлээр ТӨБЗГ-ын мэдүүлэг гаргагч албан хаагчид, харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ зэрэг нийт 262+ албан хаагчид мэдээлэл, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Мэдүүлэг гаргагч албан хаагчдад хуулийн хугацаа сануулах ажлыг тухай бүр мэдээлэл, санамж, зөвлөгөө хэлбэрээр өгсөн. Тухайлбал, ТӨБЗГ-т мэдүүлэг бүртгүүлсэн 119 албан хаагчид хуулийн хугацааг сануулж, мэдүүлгийг гаргуулан авсан бөгөөд хуулийн хугацаа хоцроосон тохиолдол гаргаагүй байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
--	--	--	--	--	---

Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх

7	4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2018 - 2022		Сүлжээний хэвийн ажиллагааг хангасан байх	<p>ТӨБЗГ – МТА (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Төрийн нэгдсэн интернэтийн сүлжээнд тус байгууллага 2022 оны 8 дугаар сард холбогдсон.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас иргэдэд шууд хүрдэг төрийн үйлчилгээ байхгүй.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдаж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, байгууллагын цахим хуудсыг хуульд нийцүүлэн шинэчлэх, хөгжүүлэх ажлыг хийв. Ингэснээр иргэн тус байгууллагын үйл ажиллагаатай танилцах, шаардлагатай мэдээллийг авах боломжийг бүрдүүлэн хэвшүүлж байна.</p> <p>Тухайлбал, төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг түрээслэхтэй холбоотой хууль тогтоомжоор батлагдсан зохицуулалт, түрээсийн гэрээ байгуулах журам, холбогдох материалыг байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn/?page_id=4746 -д байршуулах боломжийг бүрдүүлсэн. Холбогдох мэдээллийг байршуулан мэдээлсэн байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
8	4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	2018 - 2022		Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг ТББ-д шилжүүлсэн байх	<p>ТӨБЗГ – ЗУХ, хэлтэс, алба (Холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга)</p> <p>ТӨБГ-т зөвшөөрөл олгох чиг үүрэг хуулиар олгогдоогүй. Хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх шаардлага байгууллагын чиг үүргийн шинжилгээгээр тодорхойлогдоогүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>

9	4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх	2018 - 2020		Стандартыг хангуулах сургалт зохион байгуулсан байх	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ (Үндсэн хэрэгжүүлэгч: ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилладаг. Төрийн өмчийн хяналт шалгалтын 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу баримтын болон системийн 46 хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 хувь</p>
10	4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2018 - 2022		Хяналт шалгалтын тоог цөөрүүлсэн байх	<p>ТӨБЗГ – ТӨХШХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэх чиглэл барьж байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу Төрийн өмчийн хяналт шалгалтын 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу баримтын болон системийн 46 хяналт шалгалтыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хэрэгжүүлсэн. Хяналт шалгалтын хүрээнд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар шалгалтын мөрөөр авах нийт 182 арга хэмжээ, хуулийн этгээдийн ажилтнуудад болон зөвлөмжөөр нийт 398 арга хэмжээ бүхий зөвлөмж өгсөн байна. Түүнчлэн, хяналт шалгалт хийх явцад сургалт хийж, зөвлөн туслах ажлыг хийсэн.</p> <p>Мөн зөрчлөөс урьдчилан сэргийлж эрсдэлийг бууруулах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдүүдэд 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А-1/66 дугаартай албан бичгээр хүргүүлсэн албан даалгаврын хэрэгжилтийг хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдэд заалт бүрээр</p>

					гаргуулан дүгнэж ажилласан болно. Өөрийн үнэлгээ: 100 хувь
11	4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	2017 - 2022	Үнэлгээ хийлгэх ажил хэвшсэн байх	<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>ТӨБЗГ нь жил бүр ажлаа дүгнэж, цаашид авах арга хэмжээгээ тодорхойлох зорилгоор жил бүрийн сүүлийн сар, дараа оны эхний сард хэрэглэгчийн үнэлгээ хийж ажиллаж байна.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн талаар 2021 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний дүн, дүгнэлтийг 2022 оны 1 дүгээр сард гаргасан. Уг судалгаанд оролцогч 47 иргэний 19 хувь нь маш сайн, 72 хувь нь сайн, 9 хувь нь дунд гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд үнэлгээний дундаж үнэлгээ 4.1 буюу “сайн” гэж дүгнэсэн. Дүгнэлтэд тусгагдсан анхаарах асуудлыг 2022 онд анхааран ажиллах арга хэмжээ авч ажиллав.</p> <p>Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны чанар, хүртээмжийг хамтран ажиллагч байгууллагуудаас хэрхэн үнэлж дүгнэж байгаа талаар дүн шинжилгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ авах судалгааны ажлыг зохион байгуулахаар байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэв. Уг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд ТӨБЗГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу судалгааны ажлыг зохион байгуулсан. Судалгаанд 33 буюу 53.2 хувь нь төрийн өмчит хуулийн этгээдийн, 12 буюу 17.7 хувь нь төрийн захиргааны байгууллагын, 11 буюу 16.1 хувь нь бусад буюу хувийн хэвшлийн байгууллагын, 5 буюу 6.4 хувь нь төрийн тусгай албаны, 2 буюу 1.6 хувь нь төрийн үйлчилгээний байгууллагын, нийт 63 албан хаагч хамрагдсан байна. Судалгааны дүн, дүгнэлтийг батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 1 дүгээр сард багтаан гаргаж танилцуулахаар бэлтгэж байна.</p> <p>ТӨБЗГ нь АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг төрийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-нд хамрагдсан. Уг</p>

					<p>үнэлгээний судалгааны ажлыг гүйцэтгэсэн ТББ-д дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтаар хангаж, хамтран ажилласан.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
12		2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх	2018 - 2019		<p>ТӨБЗГ – ЗУХ (Төрийн үйлчилгээний байгууллага)</p> <p>ТӨБЗГ-аас иргэдэд шууд хүрдэг үйлчилгээ байхгүй.</p> <p>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг баталсан бөгөөд уг журмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аргачлал, заавар, загварыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан. Эдгээр журам, аргачлал, зааврыг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчийн үйл ажиллагааг үйлчлүүлж байгаа иргэн, хэрэглэгч үнэлэхээр тогтолцоог бий болгож журамласан. Хэрэглэгчийн зүгээс албан хаагчийн хандлага, ёс зүй, ур чадварыг 3 онооны зарчмаар дүгнэхээр аргачлал, зааварт тусгасан. ТӨБЗГ-аас иргэнд шууд үйлчлэх үйлчилгээ үзүүлдэггүй тул энэ үнэлгээ гарах боломжгүй байдаг. Харин хамт олны үнэлгээг аргачлал, зааврын дагуу нууц хэлбэрээр авч дүгнэх хэлбэрийг хэрэгжүүлж байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>
<p>Зорилт 3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх</p>					
13	4.1.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх	2017 - 2019		<p>ТӨБЗГ – ТӨБАХ (Үндсэн хэрэгжүүлэгч: ТӨБЗГ)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоол, тус тогтоолоор баталсан аргачлалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2021 оны гэрээний биелэлтийг 2022 онд нийслэл, 21 аймаг, сум, дүүрэгт төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалтай танилцаж, бүртгэлээр хяналт тавих хэлбэрээр дүгнэсэн бөгөөд төрийн өмчит 1030 хуулийн этгээд хамрагдсан байна. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 5 үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнэхэд</p>

					<p>улсын дунджаар үнэлгээ 85.3 хувийн дүнтэй байна. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 625 дугаар тогтоол гаргаж, төрийн өмчит байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч байна.</p> <p>Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн. Улсын үзлэг, тооллогод төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө, нийт 6609 нэгж (төрд 1268, орон нутгийн өмчид 5341) хамрагдсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тасалбар болгосон 91,798.5 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө хамрагдсанаас 39,735.3 тэрбум төгрөгийн төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө байна гэсэн дүн гарсан байна. Дүн, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 481 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангуулахаар тогтсон. Уг арга хэмжээний хүрээнд улсын үзлэг, тооллогын мөрөөр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, мэдээллийн санг бүрдүүлж, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулахад чиглэсэн ажлыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
14	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг	2017 - 2019		<p>ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Засгийн газрын тусгай сангийн санхүүжилтээр хэрэгжсэн ажил, төсөл, арга хэмжээ байхгүй. ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>

		зохион байгуулах				
15		2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх	2017 - 2020		Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээлдэг болсон байх	ТӨБЗГ – ЗУХ (Төсвийн ерөнхийлөн захирагч) Засгийн газрын тусгай сангийн санхүүжилтээр хэрэгжсэн ажил, төсөл, арга хэмжээ байхгүй. ТӨБЗГ-т хамаарахгүй. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u>
16		1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах	2017 - 2022		Төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгаж хэвшсэн байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) ТӨБЗГ-т хамаарахгүй. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u>
17	4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх	2018 - 2022		Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангасан байх	ТӨБЗГ – ЗУХ (Бүх шатны төрийн байгууллага) ТӨБЗГ-т хамаарахгүй. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u>
18	4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2019			ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨБАХ (Бүх шатны төрийн байгууллага) Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас тус байгууллагад учирсан хохирол гарсан тохиолдол үгүй. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u>

Зорилт 4. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх

19	4.1.4.1. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	2. Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	2017 - 2019		<p>ТӨБЗГ – ЗУХ (ТӨБЗГ), МТА, ТӨУЗХ (ТӨХЭТгээд: компани, үйлдвэрийн газар)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2022 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сард баталж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан. Тус байгууллага 2022 онд нийт 1,416.8 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс 1,200.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр, 216.8 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг улсын төсвийн урсгал зардлын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Худалдан авах ажиллагааны санхүүжилтийг эх үүсвэр, зориулалтаар нь ангилбал,</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгоход чиглэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг - 1,200.0 сая төгрөг; 2. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулахад шаардлагатай зардал (гарын авлага, материал, бусад зардал. Хуулийн дагуу 4 жил тутамд зохион байгуулах), төсвийн урсгал зардлаар – 129.7 сая төгрөг; 3. Бусад шаардлагатай худалдан авах ажиллагаа, төсвийн урсгал зардлаар – 87.1 сая төгрөг. <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжих 1.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээний санхүүжилт Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор цуцлагдсан.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2022 онд зохион байгуулагдсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд оролцогчдын мэдээлэл, шалгарсан, шалгараагүй үндэслэл, шалтгааныг төрийн худалдан авах</p>
----	---	---	-------------	--	---

						<p>ажиллагааны цахим системд нээлттэй мэдээлсэн.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж цахим системд оруулах, ил тод байршуулах талаар удирдамж өгсөн.</p> <p>ТӨБЗГ-аас 2022 онд 57 компани, үйлдвэрийн газрын 7,349.0 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үүнээс тухайн 2022 онд санхүүжих 4,577.0 тэрбум төгрөгийн 5204 худалдан авах ажиллагааг хянан баталгаажуулсан байна. Тайлант хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 14 хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 1,054.0 тэрбум төгрөгийн давхардсан тоогоор 36 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг хянан баталгаажуулсан. Эдгээр хянан баталсан төлөвлөгөөнд тусгагдсан тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
20	4.1.4.3. Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг зохистой тогтоох, түүнд хяналт тавих, өөр хоорондоо зөрүүтэй авлига гарах нөхцөл бүрдүүлэх хуулийн заалтыг хянан үзэж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	2017 - 2020		2020 он	<p>ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>
21		2. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт,	2017 - 2020		2020 он	<p>ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>

		өөрчлөлт оруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах				
22		3. "Цахим худалдан авах ажиллагаа"-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2020		2020 он	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж цахим системд оруулах, ил тод байршуулах талаар удирдамж өгсөн.</p> <p>ТӨБЗГ-аас 2022 онд 57 компани, үйлдвэрийн газрын 7,349.0 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үүнээс тухайн 2022 онд санхүүжих 4,577.0 тэрбум төгрөгийн 5204 худалдан авах ажиллагааг хянан баталгаажуулсан байна. Тайлант хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 14 хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 1,054.0 тэрбум төгрөгийн давхардсан тоогоор 36 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг хянан баталгаажуулсан. Эдгээр хянан баталсан төлөвлөгөөнд тусгагдсан тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 70 хувь</u></p>
23		4. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2019			<p>ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>
24	4.1.4.4. Концесс, шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг	1. Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг	2017 - 2019			<p>ТӨБЗГ-т хамаарахгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>

	тодорхой болгох	боловсронгуй болгох				
25	4.1.4.5. Санхүүгийн үйл ажиллагаа дахь хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх	3. Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах	2017 - 2019			ТӨБЗГ-т хамаарахгүй. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u>

Зорилт 6. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх

26		4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2018 - 2020		Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажил хэвшсэн байх	Холбогдох яам, агентлаг ТӨБЗГ-т хамаарахгүй. <u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u>
27	4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах	5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах	2017 - 2019			ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ (Холбогдох яам, агентлаг) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төсөл тус тус Улсын Их Хуралд өргөн баригдсан. УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Тус байнгын хороонд ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа болно. Дээрх хуулийн төслийг боловсруулахад зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг бий болгосон агуулга тусгагдаагүй гэж үзэж байна. <u>Өөрийн үнэлгээ: 100 хувь.</u>

Зорилт 7. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих

28	4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	2017 - 2019			<p>ТӨБЗГ – ЗУХ, хэлтэс, алба (Бүх шатны төрийн байгууллага)</p> <p>Төрийн бус байгууллага хяналт тавих бүрэн боломжтой.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, тухайлбал тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдсэн.</p> <p>Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл албан ёсны цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбарууд гэх мэт сувгаар мэдээлэгдэж байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
29	байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх	2018 - 2022		Жагсаалтад дурдсан төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн байх	<p>ТӨБЗГ – ЗУХ, хэлтэс, алба (Холбогдох яам, агентлаг)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуулиар хүлээсэн чиг үүргээс төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс санхүүжилт олгосон тохиолдол байхгүй.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: Үнэлэх боломжгүй.</u></p>
Зорилт 10. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх						
30	4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	2017 - 2022		Төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх	<p>ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ (Бүх шатны төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж)</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зааврын дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нийт 17 арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн, жилийн эцсийн байдлаар:</p>

					<p>Төлөвлөсөн нийт арга хэмжээ – 17; Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> – “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 12; – “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 2; – “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилт бүхий арга хэмжээ – 0; – “Үр дүнгүй” буюу 0 хувь, хэрэгжээгүй, тасарсан – 0; – “Үнэлэх боломжгүй” буюу өөрсдөөс хамаарахгүй болон хугацаа болоогүй байгаа арга хэмжээ – 3; <p>Хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 95.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.</p> <p>Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр 2 удаа гаргаж, ТӨБЗГ-ын 2022 оны А-4/1503, А-1/2578 дугаартай албан бичгээр АТГ-т тус тус хүргүүлсэн. Тайланг АТГ-ын “Авлигын эсрэг сүлжээ” http://khutulbur.iaac.mn цахим системд холбогдох нотлох баримт, материалын хамт оруулан баталгаажуулж, цахим хэлбэрээр мөн тайлагнасан болно.</p> <p>АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг төрийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-нд тус байгууллага хамрагдсан. Уг судалгааны ажлын гүйцэтгэгчээр сонгогдон ажилласан төрийн бус байгууллагын судалгааны багтай хамтран ажиллаж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтаар хангасан.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 100 хувь</u></p>
31	4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх	2017 - 2022	0.22	<p>Сургагч багш нарыг үе шаттайгаар сургаж, сургагч багшийн тоог нэмэгдүүлсэн байх</p> <p>ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ (Холбогдох төрийн болон ТББ)</p> <p>Авлигатай тэмцэх газрын Мөрдөгчийн мэдэгдлийн дагуу “Мөрдөгчийн мэдэгдлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөө, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтын нэгдсэн хөтөлбөр гарган “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь” сургалтыг бэлтгэн 2022.01.21-ний өдөр зохион байгуулж, ТӨБЗГ-ын 31 албан хаагчийг хамруулсан. Энэхүү сургалтын хөтөлбөрийн</p>

					<p>хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс сургалт захиалан авч, авлигын хор хөнөөл, хууль тогтоомжийн талаар цахим сургалт хийсэн бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс суртахууны асуудлаар Удирдлагын академийн багш, профессор А.Алтанзулыг урьж, нийт албан хаагчдад лекц уншуулсан. Мөн өөрийн байгууллагын сургагч багшаар “ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр сургалт хийлгэсэн.</p> <p>2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр АТГ-тай хамтран харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн ЭБАТ-д зориулсан сургалт зохион байгуулж, тэдгээрийн чадавхыг дээшлүүлэх арга хэмжээ авсан. Нийт ЭБАТ-ын 47.6 хувь (20 ЭБАТ) нь буюу сүүлийн 1 жилийн хугацаанд шинээр томилогдсон ЭБАТ-ууд танхимаар, бусад нь цахимаар хамрагдав. Уг сургалтын үйл ажиллагааны зардалд байгууллагын төсвөөс 220.0 мянган төгрөгийг зарцуулсан. Мөн сургалтын хөтөлбөрт АТГ-ын УССГХ болон ХШДШХ-ээс холбогдох сэдвийн хүрээнд мэдээлэл, семинар өгсөн. Тус сургалтад ТӨБЗГ-аас “ЭБАТ-ын үйл ажиллагаанд анхаарах асуудал” сэдвийн хүрээнд арга зүйн зөвлөгөө, зааварчилгааг дэлгэрэнгүй байдлаар өгч, ажил хэргийн ярилцлага, асуулт – хариултыг өргөн хүрээнд зохион байгуулсан. Сургалтад танхимаар оролцогчдод авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах асуудалтай холбоотой гарын авлага, ном, товхимол, зурагт хуудсыг олгосон.</p> <p>Тайлант жилд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх чиглэлээр ТӨБЗГ-ын мэдүүлэг гаргагч албан хаагчид, харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ зэрэг нийт 551 албан хаагчид сургалт, сурталчилгаа хийж, мэдээлэл, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Хамрагдалтыг ангилан танилцуулбал:</p> <ul style="list-style-type: none"> - сургалтад 170 албан хаагч; - мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгт – 262 албан хаагч; - хуулийн хугацаа сануулах арга хэмжээнд – 119 албан
--	--	--	--	--	--

						хаагч. Өөрийн үнэлгээ: 100 хувь
--	--	--	--	--	--	---

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2022 оны хэрэгжилт, үр дүнгээр тайлагнав. Тайланд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 31 арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг тусган тайлагнасан болно.

Хэрэгжилт тооцсон нийт арга хэмжээ 31, үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 16;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай буюу хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 2;
- “Үнэлэх боломжгүй” буюу өөрсдөөс хамаарахгүй байгаа арга хэмжээ – 13.

Хэрэгжилтийн дундаж хувь – 96.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

ТӨБЗГ-ын чиг үүрэгт хамаарахгүй байгаа болон бусад шалтгаанаар хэрэгжилтийг тооцох боломжгүй байгаа 13 арга хэмжээг “Үнэлэх боломжгүй” гэж үзсэн. (Арга хэмжээний дугаар: 4.1.2.2.2, 4.1.2.7.2, 4.1.3.3.1, 4.1.3.3.2, 4.1.3.4.1, 4.1.3.4.2, 4.1.4.3.1, 4.1.4.3.2, 4.1.4.3.4, 4.1.4.4.1, 4.1.1.5.3, 4.1.6.4.4, 4.1.7.3.2 зэрэг болно)

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ